



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/11/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 70003775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Албан шаардлага	20
4.3 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АТСБГ	Ахисан түвшин, сургалтын бодлогын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭШИ	Эрдэм шинжилгээ, инновац

1.Аудитын санал дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ОЧИРХУЯГ ТАНАА

2022.03.15 № 07/619
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Z:\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar-100.Docx

001051033

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа
эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн
шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	I.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,451,595,079.17	53,228,763,590.19
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,037,230,047.27	45,816,675,546.26
8	Банканд байгаа бэлэн мөнгө	40,037,230,047.27	45,816,675,546.26
9	Төгрөг	10,836,599,894.70	20,528,844,691.70
12	Арилжааны банкин дахь харилцах	10,836,599,894.70	20,528,844,691.70
16	Гадаад валют	787,476,458.74	2,652,398,627.72
19	Арилжааны банкин дахь харилцах	787,476,458.74	2,652,398,627.72
22	Хадгаламж	28,413,153,693.83	22,635,432,226.84
27	АВЛАГА	6,713,603,646.27	3,092,901,892.41
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,264,911,657.00	2,825,139,968.00
33	Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	7,136,008.95	41,695,879.87
34	Бусад авлага	441,555,980.32	226,066,044.54
35	Байгууллагаас авах авлага	400,666,715.39	189,981,971.74
36	Хувь хүмүүсээс авах авлага	40,889,264.93	36,084,072.80
43	УРЬДЧИЛГАА	409,108,758.00	622,293,845.18
50	Урьдчилгаа тооцоо	409,108,758.00	622,293,845.18
51	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	409,108,758.00	622,293,845.18
55	БАРАА МАТЕРИАЛ	3,291,652,627.63	3,696,892,306.34
56	Түүхий эд материал	78,335,448.52	93,427,033.55
57	Тусгай зориулалттай материал	5,640,203.11	5,640,203.05
58	Эм боох материал	2,784,468.41	17,876,053.50
59	Дуусаагүй үйлдвэрлэл	69,910,777.00	69,910,777.00
61	Хангамжийн материал	3,213,317,179.11	3,603,465,272.79
62	Бичиг хэргийн материал	17,635,435.29	34,278,087.62
63	Аж ахуйн материал	832,340,559.05	767,830,381.43
64	Сэлбэг хэрэгсэл	150,684,349.22	102,715,501.38
65	Түлш, шатах тослох материал	4,279,299.20	6,366,549.20
66	Барилгын засварын материал	88,231,794.54	74,545,642.69
67	Хүнсний материал	1,807,617.97	81,077.97
68	Бусад хангамжийн материал	2,118,338,123.84	2,617,648,032.50
82	II.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	67,798,005,363.97	68,964,279,508.84
105	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	67,798,005,363.97	68,964,279,508.84
107	Биет хөрөнгө	63,122,018,352.77	64,338,741,862.56
108	Барилга, байгууламж, орон сууц	51,770,366,516.67	51,788,306,516.67
109	Хуримтлагдсан элэгдэл	(3,756,957,958.40)	(5,461,315,352.26)
110	Авто-тээврийн хэрэгсэл	711,060,636.00	884,319,636.00
111	Хуримтлагдсан элэгдэл	(392,083,121.80)	(531,977,779.54)
112	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,072,469,630.24	24,446,985,658.24

113	Хуримтлагдсан элэгдэл	(13,989,756,682.28)	(16,850,576,432.14)
114	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,400,216,771.16	7,481,226,786.16
115	Хуримтлагдсан элэгдэл	(4,102,158,605.30)	(4,694,294,984.16)
121	Бусад үндсэн хөрөнгө	240,745,167.51	250,545,167.51
122	Хуримтлагдсан элэгдэл	(140,037,998.16)	(148,319,219.84)
123	Дуусаагүй барилга, байгууламж	160,000,000.00	3,819,773,587.00
124	Ном	3,148,153,997.13	3,354,068,278.92
125	Биет бус хөрөнгө	4,675,987,011.20	4,625,537,646.28
126	Программ хангамж	684,902,153.30	736,213,463.30
127	Хуримтлагдсан элэгдэл	(249,475,911.10)	(368,936,586.02)
128	Бусад биет бус хөрөнгө	4,240,560,769.00	4,258,260,769.00
136	III.НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	118,249,600,443.14	122,193,043,099.03
137	IV.НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,433,716,425.42	6,803,549,221.31
138	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,433,716,425.42	6,803,549,221.31
163	Өглөг	88,102,082.30	74,948,309.86
164	Ажилчидтай холбогдсон өглөг	3,157,256.84	1,338,085.85
165	Бараа үйлчилгээний зардлын өглөг	84,944,825.46	73,610,224.01
169	Бусад өглөг	37,676,410.05	48,178,555.97
170	Байгууллагад төлөх өглөг	83,810.05	83,810.05
171	Хувь хүмүүст төлөх өглөг	29,685,000.00	34,641,227.00
172	Татварын өглөг /ТӨҮГ/	-	7,477,546.04
175	Дансны өглөг /ТӨҮГ/	7,888,000.00	5,975,972.88
177	Урьдчилж орсон орлого	5,307,937,933.07	6,680,422,355.48
179	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	5,307,937,933.07	6,177,668,841.04
181	Бусад урьдчилж орсон орлого	-	502,753,514.44
218	V.ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	112,815,884,017.72	115,389,493,877.72
219	Засгийн газрын хувь оролцоо	20,201,535,374.47	20,201,535,374.47
221	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	20,201,535,374.47	20,201,535,374.47
227	Хуримтлагдсан үр дүн	92,614,348,643.25	95,187,958,503.25
228	Өмнөх үеийн үр дүн	80,738,366,905.94	80,738,366,905.94
229	Тайлант үеийн үр дүн	-	2,573,609,860.00
231	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,875,981,737.31	11,875,981,737.31
235	VI.ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	118,249,600,443.14	122,193,043,099.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	А		
1	I.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	53,198,763,507.79	56,488,747,261.42
2	ТАТВАРЫН ОРЛОГО		
3	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,081,095,567.79	55,989,938,741.93
4	Нийтлэг татварын бус орлого	3,474,187,892.43	1,650,477,404.94
6	Хүүгийн орлого	3,008,201,125.43	1,348,605,054.17
7	Торгуулийн орлого	465,986,767.00	301,872,350.77
8	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,315,431,475.36	54,288,783,836.99
9	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,382,201,862.72	47,081,679,358.04
10	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,277,297,636.09	6,044,138,047.76
12	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	79,633,000.00	251,592,182.59
13	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	265,703,637.05	315,657,679.84
15	Түрээсийн орлого	71,252,420.00	91,371,490.00
20	Засгийн газрын хөнгөлөлт	2,239,342,919.50	504,345,078.76
27	Тусламжийн орлого	177,150,000.00	50,677,500.00
28	Хандив тусламж /дотоод/	30,150,000.00	-
29	Хандив тусламж /гадаад/	147,000,000.00	50,677,500.00
30	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	114,326,200.00	-
31	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	114,326,200.00	-
39	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	117,667,940.00	498,808,519.49
40	Улсын төвлөрсөн төсвөөс	-	498,808,519.49
47	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		498,808,519.49
57	Орон нутгийн төсвөөс санхүүжих	117,667,940.00	-
58	Төсвийн захирагчдаас	117,667,940.00	-
63	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	117,667,940.00	-
68	II.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	50,181,544,134.52	53,874,073,898.67
69	УРСГАЛ ЗАРДАЛ	50,181,544,134.52	53,874,073,898.67
70	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,181,544,134.52	53,874,073,898.67
71	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,314,473,332.49	30,855,448,098.26
72	Үндсэн цалин	29,314,473,332.49	30,855,448,098.26
77	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,687,068,579.76	4,040,618,310.17
78	Тэтгэврийн даатгал	2,550,762,109.26	4,040,618,310.17
83	Байр ашиглалттай холбоотой зардал	940,901,164.94	929,147,127.20
84	Гэрэл, цахилгаан	438,288,894.89	394,747,683.39
85	Түлш, халаалт	393,419,478.85	417,099,884.88
86	Цэвэр, бохир ус	109,192,791.20	102,958,508.93
87	Байрны түрээс	-	14,341,050.00
88	Хангамж, бараа материалын зардал	1,215,100,681.65	1,153,698,804.36
89	Бичиг хэрэг	113,538,390.85	176,672,279.85
90	Тээвэр шатахуун	30,028,394.12	19,438,671.30
91	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,176,356.07	234,651,041.82
92	Ном, хэвлэл	68,293,924.67	79,533,176.34
94	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	671,720.00
95	Аж ахуйн материал худалдан авах	763,063,615.94	642,731,915.05

98	Нормативд зардал	11,131,186.35	-
99	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,555,186.35	-
101	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,576,000.00	-
102	Эд хогшил, урсгал засварын зардал	1,263,698,420.67	1,423,114,387.70
106	Урсгал засвар	1,263,698,420.67	1,423,114,387.70
107	Томилолт, зочны зардал	96,988,700.62	196,354,405.24
108	Гадаад албан томилолт	25,583,553.45	42,275,530.12
109	Дотоод албан томилолт	11,051,284.00	23,764,175.40
110	Зочин төлөөлөгч хүлээн авах	60,353,863.17	130,314,699.72
111	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	831,093,114.14	1,023,842,024.83
112	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	366,683,315.20	369,250,480.00
119	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	464,409,798.94	654,591,544.83
126	Бараа үйлчилгээний бусад зардал	12,111,520,018.37	13,632,824,082.20
127	Бараа үйлчилгээний бусад зардал	742,594,226.59	913,011,783.66
128	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,174,792,461.31	7,362,906,009.74
129	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,194,133,330.47	5,356,906,288.80
141	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	709,568,935.53	619,026,658.71
145	Бусад урсгал шилжүүлэг	709,568,935.53	619,026,658.71
153	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	709,568,935.53	619,026,658.71
173	IV.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	569,784,764.31	24,928,802.18
174	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	565,572,764.31	23,108,802.18
175	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,212,000.00	1,820,000.00
180	V.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	156,489,495.56	65,992,304.93
181	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,104,647.72	-
182	Найдваргүй авлагын алдагдал	83,611,360.00	-
184	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	37,773,487.84	65,992,304.93
191	VI.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,430,514,642.02	2,573,609,860.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр ашиг	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	80,738,366,905.94	112,815,884,017.72
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
3	НББүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	2,573,609,860.00	2,573,609,860.00
5	2021 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	83,311,976,765.94	115,389,493,877.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО		
3	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,542,142,599.00	8,207,993,694.00
4	Улсын төсвөөс	-	-
5	Тэтгэвэр тэтгэмж		
6	Бусад / Замын зардал /		
7	Орон нутгийн төсвөөс / МСҮТ, Ахлах сургууль /	114,326,200.00	113,391,000.00
8	Бусад төсөвт байгууллагаас / CTC/	1,086,575,459.00	7,090,221,361.00
9	Бусад тусгай зориулалтын сангаас / төсөл, хөтөлбөр /	341,240,940.00	1,004,381,333.00
10	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	44,982,498,307.19	52,500,235,438.16
11	Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлого	36,851,484,360.41	44,398,387,548.96
12	Торгууль, төлбөрийн орлого	8,131,013,946.78	8,101,847,889.20
13	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	46,524,640,906.19	60,708,229,132.16
14	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА		
15	АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	30,945,121,886.48	34,448,350,735.68
16	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	29,334,824,505.29	30,860,177,536.24
17	Цалин	29,334,824,505.29	30,860,177,536.24
18	Нийгмийн даатгал	1,610,297,381.19	3,588,173,199.44
19	НДШ-ийн зардал	1,610,297,381.19	3,588,173,199.44
20	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,644,247,616.44	13,623,941,535.46
21	Нийтлэг чанартай зардал	5,047,171,844.28	5,256,551,874.58
22	Бичиг хэргийн зардал	54,470,870.48	56,964,339.16
23	Гэрэл цахилгааны зардал	439,854,942.50	407,785,418.39
24	Түлш, халаалтын зардал	398,270,080.76	420,513,446.53
25	Цэвэр, бохир усны зардал	112,541,332.20	103,204,334.93
26	Тээвэр, шатахууны зардал	34,603,089.11	25,562,150.00
27	Шуудан холбоон,интернэтийн зардал	240,867,016.07	235,171,881.67
28	Томилолтын зардал	14,763,709.00	24,838,675.40
29	Дотоод	14,763,709.00	24,838,675.40
30	Ном, хэвлэлийн зардал / Тогтмол хэвлэлийн зардал /	23,677,105.00	24,118,675.00
31	Аж ахуйн материал худалдан авах зардал	844,329,664.66	717,558,185.82
32	Урсгал засварын зардал	1,303,929,511.93	1,440,102,419.33
33	Сургалт семинарын зардал / Багшийг дэмжих зардал /	648,866,872.67	630,822,541.32
34	Төлбөр, хураамж+Банкны шимтгэл	502,762,859.23	735,486,048.83
35	Харуул, хамгаалалтын зардал	366,685,316.00	369,250,480.00
36	Маягт хэвлүүлэх зардал / Хэвлэл мэдээлэл суртал. Зардал/	61,549,474.67	65,173,278.20
37	Тусгай материал, үйлчилгээний зардал	6,597,075,772.16	8,367,389,660.88
38	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,059,986,759.13	1,935,482,662.43
39	Эрдэм шинжилгээний ажлын зардал	4,477,787,191.46	4,990,800,831.33

40	Оюутны үйлчилгээний зардал	754,919,849.14	972,244,881.69
41	Гадаадын арга хэмжээ, зочны зардал	91,766,760.43	190,793,738.24
42	Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	33,974,995.00	60,182,424.18
43	Салбарын төвлөрсөн арга хэмжээ	178,640,217.00	217,885,123.01
44	ТАТААС, САНХҮҮЖИЛТ	676,603,942.34	551,417,012.00
45	Бусад санхүүжилт	676,603,942.34	551,417,012.00
46	Оюутны тэтгэлэг /Замын зардал/		
47	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	676,603,942.34	551,417,012.00
48	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	43,265,973,445.26	48,623,709,283.14
49	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,258,667,460.93	12,084,519,849.02
50	Хөрөнгийн зарлага	3,064,805,049.42	6,305,074,350.03
51	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	3,064,805,049.42	6,305,074,350.03
52	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	3,064,805,049.42	6,305,074,350.03
53	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,064,805,049.42)	(6,305,074,350.03)
54	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТЭНЦЭЛ	193,862,411.51	5,779,445,498.99
55	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨ		
56	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
57	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	193,862,411.51	5,779,445,498.99
58	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,843,367,635.76	40,037,230,047.27
59	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,037,230,047.27	45,816,675,546.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ МӨНГӨН ДҮН	90,493,938,257.40	100,745,459,179.43
Мөнгөн хөрөнгийн 2021.01.01-ний үлдэгдэл	42,193,787,600.98	40,037,230,047.27
Тайлант жилийн орлого	48,300,150,656.42	60,708,229,132.16
Үндсэн үйл ажиллагааны орлого	40,821,712,869.20	52,606,381,242.96
Төсвийн санхүүжилт	852,697,101.86	1,117,772,333.00
Хөрөнгө оруулалт СТТ, лаборатори		
Бодлогын дэмжлэг, ЭШ төсөл хөтөлбөр	601,500,000.00	1,004,381,333.00
Лицей сургуулийн хувьсах зардал	118,195,000.00	113,391,000.00
Тэтгэвэр тэтгэмж	16,841,101.86	
Оюутны замын зардал	116,161,000.00	
Сургалтын төлбөрийн орлого	39,969,015,767.34	51,488,608,909.96
Бакалаврын сургалтын төлбөр	35,360,919,744.95	45,221,365,529.90
Магистрын сургалтын төлбөр	2,402,010,996.49	3,696,348,246.77
Докторын сургалтын төлбөр	474,746,486.90	628,007,397.20
Гадаад оюутны төлбөр	801,338,539.00	893,474,140.00
Лицей сургуулийн сургалтын төлбөр	930,000,000.00	1,049,413,596.09
Туслах үйл ажиллагааны орлого	7,478,437,787.22	8,101,847,889.20
Оюутны дотуур байрны	956,754,800.00	406,994,617.23
Гадаад оюутны байрын орлого	85,741,200.00	65,342,500.00
Дотоод оюутны байрын орлого	871,013,600.00	341,652,117.23
Үйл ажиллагааны бус орлого	6,521,682,987.22	7,694,853,271.97
ААТ нэгжийн орлого	857,203,550.44	1,073,663,562.61
ЭШ-ний гэрээт ажил, төслөөс орох	3,038,522,111.88	4,070,388,678.33
Түрээсийн орлого	70,952,120.00	87,936,090.00
Хадгаламжийн хүүгийн орлого	1,440,050,000.00	1,548,793,828.91
Оюутны тэтгэлгийн орлого	142,000,000.00	55,326,770.83
Хандив	6,500,000.00	5,850,000.00
Зуны болон түр сургалтын орлого	155,350,000.00	137,860,289.97
Диплом, үнэмлэхийн орлого	73,509,000.00	97,054,407.00
Хураамж, бусад	737,596,204.90	617,979,644.32
НИЙТ ЗАРДАЛ	68,629,024,926.36	54,928,783,633.17
А. УРСГАЛ ЗАРДАЛ	55,152,904,259.26	48,913,212,177.84
Цалин хөлсний зардал	35,443,646,760.06	34,448,350,735.68
Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	31,499,594,988.94	30,860,177,536.24
НДШ	3,944,051,771.12	3,588,173,199.44
Бараа үйлчилгээний нийтлэг зардал	5,595,052,206.95	4,027,827,330.55
Бичиг хэргийн зардал / захиргаа /	114,609,420.50	56,964,339.16
Аж ахуйн зардал	842,773,983.00	693,505,462.82
Шуудан холбооны зардал	46,764,400.80	35,899,083.56
Шатахуун, сэлбэгийн зардал	54,871,610.00	25,562,150.00
Албан томилолт / захиргаа /	50,277,640.00	24,838,675.40
Шагналын зардал	63,670,000.00	55,168,854.01
Төвлөрсөн арга хэмжээний зардал	226,930,000.00	58,049,329.00
Ахмадын сан	121,798,935.79	104,666,940.00
ГАХ, хамтын ажиллагааны зардал	579,474,000.00	180,993,738.24
Тусламж тэтгэлгийн зардал	132,500,000.00	118,847,240.00
Тэтгэвэр тэтгэмжийн зардал	507,580,326.86	432,569,772.00
Урсгал засварын зардал	1,796,202,700.00	1,440,102,419.33
Төлбөр хураамжийн зардал	930,745,190.00	735,486,048.83

Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардал	126,854,000.00	65,173,278.20
Сургалтын үйлчилгээний зардал	5,927,472,567.75	3,893,695,270.73
Тогтмол хэвлэлийн зардал	44,816,480.00	24,118,675.00
Хичээл практикийн зардал	3,110,767,420.85	1,956,141,255.92
Интернэтийн зардал	290,188,600.00	199,272,798.11
Оюутны үйл ажиллагааг дэмжих зардал	371,435,000.00	183,324,111.69
Оюутны тэтгэлэг	819,700,000.00	788,920,770.00
Оюутны замын зардал	116,161,000.00	
Уралдаан тэмцээний зардал	81,724,000.00	60,182,424.18
Мэргэжлийн олимпиадын зардал	195,089,700.00	30,124,871.51
Гадаад багшийн зардал	71,075,200.00	9,800,000.00
Багш, ажилтны үйл ажиллагааг дэмжих зардал	826,515,166.90	641,810,364.32
Эрдэм шинжилгээ, инновацын зардал	6,569,128,312.50	5,242,585,161.03
Эрдэм шинжилгээ хурал, инновацын зардал	1,347,230,468.00	1,090,236,052.97
ЭШИ төсөл бусад эх үүсвэрээс	2,860,083,280.00	3,171,478,981.15
Пост доктор	237,914,537.50	23,979,398.88
Ассистантшип	202,665,000.00	112,295,610.21
Судалгааны лабораторийн магадлан итгэмжлэл	26,091,220.00	-
АТСБГ-ын зардал	302,807,745.00	27,152,900.00
Судалгааны суурь зардал	470,000,000.00	352,670,801.87
Өндөр түвшний судалгаа, залуу судлаач, тэтгэлэг, хамтарсан төслийн дэмжлэг	433,713,048.00	338,654,813.00
Залуу судлаачдын багийн грант	80,000,000.00	36,669,270.00
Зочин судлаачдын грант	240,623,014.00	50,015,596.99
Зочин профессор нээлттэй ажлын байр	54,000,000.00	5,686,125.00
Бодлогын судалгааны төв	314,000,000.00	33,745,610.96
Тогтмол зардал	1,617,604,412.00	1,300,753,679.85
Гэрэл цахилгаан	565,261,460.00	407,785,418.39
Халаалтын зардал	494,356,978.00	420,513,446.53
Цэвэр, бохир усны зардал	167,085,970.00	103,204,334.93
Харуул хамгаалалтын зардал	390,900,004.00	369,250,480.00
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,476,120,667.10	6,015,571,455.33
Хөрөнгийн зардал	13,476,120,667.10	6,015,571,455.33
Барилгын хөрөнгө оруулалт	9,933,527,231.10	3,530,578,307.00
Барилга байгууламжийн ИЗ-ын зардал	448,840,686.00	
Тоног төхөөрөмж худалдан авах зардал	2,035,147,750.00	2,033,165,163.00
Тавилга, эд хогшил худалдан авах зардал	355,705,000.00	66,821,150.00
Ном сурах бичиг худалдан авах зардал	387,400,000.00	181,495,525.32
Тээврийн хэрэгсэл		
Биет бус хөрөнгө	315,500,000.00	203,511,310.01
Улсын төсвийн хөрөнгө оруулалт-лаборатори	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалт-номын сан	-	-
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ 2021.12.31		45,816,675,546.26

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол улсын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардлын ангилал буруу бүртгэсэнтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн, Б.Үжин нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг хэрэгжүүлсэн.

Монгол улсын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 4а/241 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байна.

МУИС-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн ололт, сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд тулгуурласан бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах;
- Шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж сургалт, судалгаанд нэвтрүүлэх, инновацын бодлого хэрэгжүүлэх;
- Нийгэмд эрдэм мэдлэг түгээх, соён гэгээрүүлэх, Монгол Улсын хөгжил дэвшилд чиглэсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж боловсруулж дэвшүүлэх;
- Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, үндэсний хэл, соёл, түүхийн дархлааг бэхжүүлэх хүрээнд монгол судлалыг хөгжүүлэх;
- Багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах хэвийг нөхцөлийг бүрдүүлэх, эрхийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Хөдөлмөрийн тухай хууль
- Захирлын 2021.1.20-ны өдрийн А/13 тушаалаар “МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам” баталсан.
- Захирлын 2021.03.24-ний өдрийн А/63 тоот тушаалаар “МУИС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах” дотоод журам
- Захирлын 2021.11.12-ний өдрийн А/224 тоот тушаалаар “МУИС-ийн харьяа нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, үнэлгээ хийх журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэл хийгдээгүй боловч 2021 онд БШУЯ-ны НБББББ шинэчлэгдсэн ба тус бодлогын баримт бичгийн 5.12-т "Төрийн өмчит их дээд сургуулийн НББ, тайлагналын онцлог" бүлгийг нэмж оруулсантай холбогдуулан МУИС-ийн НБББББ боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, төсөл эцсийн хэлэлцүүлэгт байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Засгийн газрын 483 дугаар тогтоолын дагуу ТШЗ өөрийн хариуцах асуудлын хамрах хүрээнээс шалтгаалан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод аудитор ажиллуулж болох ба тус сургуулийн цар хүрээ өргөн олон нэгж, салбар бүрэлдэхүүн сургуультай учир тайлант онд дотоод хяналтын ажил Захирлын тоот тушаалаар томилогдсон нэгж байгуулагдан ажиллаж байгаа хэдий ч санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хяналтыг хэрэгжүүлдэггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

МУИС нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, компанийн тухай хууль болон СТОУС түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

МУИС-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсөвлөсөн нийт орлогын 48,300.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 483.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн гүйцэтгэлийн үед тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

МУИС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,943.4 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40,037.23	45,816.68	5,779.45
Авлага	6,713.60	3,092.90	(3,620.70)
Урьдчилгаа	409.11	622.29	213.19
Бараа материал	3,291.65	3,696.89	405.24
Үндсэн хөрөнгө	63,122.02	64,338.74	1,216.72
Биет бус хөрөнгө	4,675.99	4,625.54	(50.45)
Нийт хөрөнгийн дүн	118,249.60	122,193.04	3,943.44
Өр төлбөр	5,433.72	6,803.55	1,369.83
Эздийн өмч	112,815.88	115,389.49	2,573.61
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	118,249.60	122,193.04	3,943.44

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 45,816.7 сая төгрөг болж 5,779.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд цар тахалтай холбоотойгоор төлөвлөсөн зардлууд, төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын зориулалтаар он дамжуулсан мөнгөн хөрөнгийг хадгаламжаар байршуулан хүүгийн орлого орсон;
- Авлага дансны үлдэгдэл 3,092.9 сая төгрөг болж 3,620.7 сая төгрөгөөр буурсан нь 2019-2020 оны хичээлийн жилд үүссэн төлбөртэй үйлчилгээний авлага буюу сургалтын төлбөрийн авлага Боловсролын зээлийн сангаас 3,425.3 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн авлага төлөгдсөн;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 622.3 сая төгрөг болж 213.2 сая төгрөгөөр өссөн нь программ хангамжийн урьдчилгаа 134.5 сая төгрөг, бараа материал авах 68.9 сая төгрөг, “Дижитал МУИС түүчээ төсөл” -д урьдчилгаа олгосон;
- Бараа материал дансны үлдэгдэл 3,696.9 сая төгрөг болж 405.3 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой цэвэрлэгээ, халдвар хамгаалалт, эм эмнэлгийн хэрэглэл, хамгаалалтын хэрэгсэл, цахим хичээлтэй холбоотой сургалтын болон захиргааны хэрэгцээний бичиг хэргийн материал, жижиг төхөөрөмж худалдан авсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97,019.6 сая төгрөг болж 6,591.2 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 6,183.6 сая төгрөг, хандиваар авсан 356.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.
- ТӨБЗГ-ын 2021 оны 204 тоот тогтоолын дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-аас 122.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 67.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, Монгол дахь Жайкагийн төлөөлөгчийн газраас 51.2 сая төгрөгийн үнэтэй автомашинуудыг тус тус шилжүүлэн авсан.
- Биет бус хөрөнгө 736.2 сая төгрөг болж 51.3 сая төгрөгөөр өссөн нь 35.3 сая төгрөгийн программын лиценз худалдан авсан, 10.0 сая төгрөгийн Элэг хамгаалах патентын орлогыг бүртгэсэн;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 6,803.5 сая төгрөг болж 1,369.8 сая төгрөгөөр өссөн нь сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого нэмэгдэж, нийт өр төлбөрийн 90.8 хувийг эзэлснээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны үйл ажиллагааны төсвийн орлогыг урьд оны үлдэгдлээс 42,193.7 сая төгрөг, тайлант жилийн орлогоос 48,300.1 сая төгрөг нийт 90,493.9 мянган төгрөгөөр, урсгал зардалд 55,152.9 сая төгрөг, төсвийн жилд гүйцэтгэх хөрөнгө оруулалтыг 13,476.1 сая төгрөгөөр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урьд оны үлдэгдлээс 40,037.2 сая төгрөг, тайлант жилийн орлого 60,708.2 сая төгрөг нийт 100,745.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 54,928.8 сая төгрөгийн зардал гарган, 13,700.2 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 48,913.2 сая төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 995.3 сая төгрөг, бараа үйлчилгээний нийтлэг зардлыг 1,567.2 сая төгрөг, сургалтын үйлчилгээний зардал 2,033.8 эрдэм шинжилгээ, инновацын зардлыг 1,326.5 сая төгрөг, тогтмол зардлыг 316.9 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/					
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тайлант жилийн орлого	48,300.10	60,708.20	12,408.10	125.7%
1.1	Үйл ажиллагааны урсгал зардал	55,152.90	48,913.20	(6,239.69)	88.7%
1.2	Хөрөнгийн зардал	13,476.12	6,015.57	(7,460.54)	44.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд худалдан авсан бараа ажил үйлчилгээний төлбөрт 9.2 сая төгрөгийг мэдээ, сурвалжилгыг нийтлүүлэхээр 5 хэвлэл мэдээллийн байгууллагад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

МУИС-ийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитын явцад тус сургуулийн 15 нэгжийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 6 орлогын гүйлгээ, зарлагын 5 гүйлгээний 58.8 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Мэндчилгээ, бэлэг дурсгал, цэцэг, зочин төлөөлөгчийн зардалд 45.2 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3 дугаар зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн тооцоо нийлж баталгаажуулаагүй авлага, ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд нөхөн олговор олгосон зөрчилд 2 албан шаардлагын биелэлт 50.0 хувь, 147.2 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	40.4	2	14.2	1	26.2	50.0
Зөвлөмж	4	147.2	4	147.2	-	-	100.0
Нийт дүн	7	187.6	6	161.4	1	26.2	75.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. БШУЯ-аас хэрэгжүүлж буй "Инженер технологийн дээд боловсрол" төслөөс нийлүүлэх 109 нэр төрлийн 148 ширхэг 3.2 сая ам.долларын үнэ бүхий багаж тоног төхөөрөмж хүлээн авахаас цар тахалтай холбоотойгоор урьдчилсан байдлаар 94 нэр бүхий төрлийн багаж төхөөрөмж ирүүлсэн ба хөрөнгийг бүрэн хүлээн авсан үед орлогоор бүртгэх тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.
2. Завхан, Эрдэнэт дэх салбар сургуулийн сургалтын хичээл сонголтын программын мэдээлэл ирүүлээгүй тул тус салбар сургуулиудын авлага, урьдчилж орсон орлогын тулгалтыг хийгээгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 449,013.9 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 181.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 42.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 82.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 124.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 483.0 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын төлөвлөлтийг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасныг засварлуулан;
- Захиргаа төвлөрсөн санд үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй 103.1 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмж байгааг элэгдлийг тооцоолсон;
- ШУС-захиргаа хандиваар хүлээн авсан автомашины элэгдлийг бүртгэхдээ хандивын орлогыг 67.9 сая төгрөгөөр бууруулан буруу бичилт хийснийг тус тус залруулж тайланд тусгав.

4.2 Албан шаардлага

1. Анхан шатны дэмжих баримтгүй фитнесийн зардал 1.2 сая төгрөг, бичиг хэргийн зардлын 0.2 сая төгрөгийг анхан шатны баримт зөрүүтэй цай кофены зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын иж бүрэн байдлыг хангасан гүйлгээг бүртгэлд тусган ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Бүрэлдэхүүн 5 сургуулийн сургалтын төлбөрийн программын сургалтын төлбөрийн авлага, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад авлага 1.2 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 2.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрийн программын үлдэгдлийг тухай бүр хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгаж байх, Албан шаардлага өгөх.

3. Ажлаас үндэслэлгүй халсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 37.4 сая төгрөгийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний

хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ гэж заалттай нийцээгүй, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна гэж заасан.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцан шийдвэр буруу гаргасан этгээдээр төлүүлэх, Албан шаардлага хүргүүлэх..

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Магистр докторантурт суралцаж байгаа оюутнуудыг гэрээт ажилтнаар авч ажиллуулсан цалингийн зардал 80.2 сая төгрөгийг оюутны тэтгэлгийн зардлын ангилалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3-т Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-т зардлын төрөл ангиллыг тодорхой тусгах, дагалдах журамд нарийн зааж өгөх.

2. Харилцах данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Данс андуурсан орлогоос 1.8 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг шат шатны хяналт хийн нягталж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/сая төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Анхан шатны дэмжих баримтгүй фитнесийн зардал 1.2 сая төгрөг, бичиг хэргийн зардлын 0.2 сая төгрөгийг анхан шатны баримт зөрүүтэй цай кофены зардалд зарцуулсан байна.	Анхан шатны дэмжих баримтгүй гүйлгээг бүртгэсэн.	1	1.4					1	1.4				
2	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Бүрэлдэхүүн 5 сургуулийн сургалтын төлбөрийн программын сургалтын төлбөрийн авлага, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад авлага 1.2 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 2.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, урьдчилж орсон орлогын дүнг зөрүүтэй тусгасан.	1	3.4					1	3.4				
3	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Ажлаас үндэслэлгүй халсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 37.4 сая төгрөгийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон байна.	Нөхөн олговрыг байгууллагаас олгосон байна.	1	37.4					1	37.4				
4	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Магистр докторантурт суралцаж байгаа оюутнуудыг гэрээт ажилтнаар авч ажиллуулсан цалингийн зардал 80.2 сая төгрөгийг оюутны тэтгэлгийн зардлын ангилалд бүртгэсэн байна.	Зардлын ангилал буруу бүртгэсэн байна.	1	80.2									1	80.2
5	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Данс андуурсан орлогоос 1.8 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.	Зарлагыг илүү гаргасан.	1	1.8									1	1.8
6	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын төлөвлөлтийг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасныг залруулсан.	Төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй бэлтгэсэн.	1	10.0	1	10.0								
7	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	Захиргаа төвлөрсөн санд үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй 103.1 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмж байгааг элэгдлийг тооцоолон залруулсан.	Хуримтлагдсан элэгдлийг тооцоогүй байна.	1	103.1	1	103.1								
8	МУИС	АХГ-2022/11/НА-СТА-ТӨА	ШУС-захиргаа хандиваар хүлээн авсан автомашины элэгдлийг бүртгэхдээ хандивын орлогыг 67.9 сая төгрөгөөр бууруулан буруу бичилт хийснийг залруулсан.	Дансны буруу бичилтийг хийсэн байна.	1	67.9	1	67.9								
ДҮН					8	305.2	3	181.0	-	-	3	42.2	-	-	2	82.0

Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
1	МУИС	АХГ- 2022/11/НА- СТА-ТӨА	Тус сургуулийн 15 нэгжийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 6 орлогын гүйлгээ, зарлагын 5 гүйлгээний 58.8 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй байна.	1	58.8					1	58.8	1	-
2	МУИС	АХГ- 2022/11/НА- СТА-ТӨА	Мэндчилгээ, бэлэг дурсгал, цэцэг, зочин төлөөлөгчийн зардалд 45.2 сая төгрөгийг зарцуулсан.	Дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.	1	45.2					1	45.2		
ДҮН					2	104.0					2	104.0	1	-
НИЙТ ДҮН					10	409.2	3	181.0	-	-	5	146.2	1	-
													2	82.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 573/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022 / 11 / НД - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны дэмжих баримтгүй фитнесийн зардалд 1,262,700.00 төгрөг, бичиг хэргийн зардлын ангиллаар 187,800.00 төгрөгийг цай кофены зардлаар анхан шатны баримт бүрдүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуяг, Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал Ц.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Э.НАНДИНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

2 \\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-243.Docx

0001081467



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 574/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/11/НА-СТА-ТӨА.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүрэлдэхүүн 5 сургуулийн сургалтын төлбөрийн программын сургалтын төлбөрийн авлага, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад авлага 1,200,000.00 төгрөгөөр, урьдчилж орсон орлого 2,200,000.00 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 "Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сургалтын төлбөрийн авлага, урьдчилж орсон орлогод тухай бүр хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуяг, Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал Ц.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Э.НАНДИНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

2022.03.15

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-244.Docx

0001081468



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 577/АО150058

Улаанбаатар хот

АХГ-2022/11/НА-СТА-ТДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас үндэслэлгүй халагдсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 37,491,480.00 төгрөгийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагыг хохиролгүй болгож, буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгаланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТЫН
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Э.НАНДИНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

9019120396

Z:\Alban Shardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-242.Docx

0001081464



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 545/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 2022 /11/НА-С1А-Т0А

「 Сахилгын хариуцлага тооцуулах тухай 」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн 15 нэгжийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс орлогын 6 гүйлгээ, зарлагын 5 гүйлгээний 58,800,000.00 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Шилэн дансны мэргэжилтэн Г.Гантуяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Их Сургуулийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуягт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Э.НАНДИНЧИМЭГ

0001081471



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 576/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/11/НА-СТА-ТРА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Мэндчилгээ, бэлэг дурсгал, цэцэг, зочин төлөөлөгчийн зардал 45,200,000.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуяг, Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал Ц.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Э.НАНДИНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага найруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-284230

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-246.Docx

0001081474